

Орх буюуний пролетариат нар нэгдэгтүн! АНХДЭГТААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 45 (2309) 1974 оны 6 дугаар сарын 13 ПҮРЭВ

УХУУЛГЫН ҮР НӨЛӨӨ

Намын ухуулга олон түмний ажлын одоогийн гол зорилт бол түүний үр нөлөөг дээшлүүлэх явдал юм. Ухуулга олон түмний ажлын шинжлэх ухааны үндэс, үр нөлөөг дээшлүүлэхдээ юуны өмнө Марксист-Ленинист үзлийг социалист байгуулалтын зорилттой нягт холбоон гүдгэгийг сурталчлах, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашгийг дхиулаж аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилтыг биелүүлэх, хөдөлмөрчдийн ахуйн соёлын түвшинг дээшлүүлэхэд түүнийг чиглүүлэх, ухуулгын арга хэлбэрийг улам боловсронгуй болгохыг улсын тэргүүний суртал нэвтрүүлэгч, ухуулагчдын II зөвлөлгөөн цохон тэмдэглэсэн билээ.

Иймээс ухуулгыг амьдралтай нягт холбож түүний үр нөлөөг дээшлүүлэх гол арга бол тухайн хамт олон, аж ахуй соёлын байгууллагын өмнө тавигдаж байгаа зорилтыг ухуулгын үндсэн сэдэв болгож түүнийг тойруулан ухуулга зохион байгуулалтын олон талт арга хэмжээ авч явуулах явдал юм.

Намын ухуулгын үр нөлөөг дээшлүүлж ухуулгад дэвшилтэт шинэ арга барилыг нэвтрүүлэн, хөдөлмөрийн хамт олны бүтээлч идэвхийг өрнүүлж чадсан газар төлөвлөгөөт зорилт амжилттай биелэгдэгийг Жаргалант, Борнуур, Батсүмбэр, Эрдэнэсант сумд, аймгийн Зам ашиглалтын анги, сонин үйлдвэр зэрэг олон байгууллагын ажлын бүтээл харуулж байна.

Намын ухуулга суртал нэвтрүүлгийн нэг чухал зорилт нь хүн бүрийн хөдөлмөр, нийгмийн өмчид социалист ёсоор хандаж болгохын зэрэгцээ социалист уралдааныг эрчимтэй өрнүүлж, тэргүүний арга туршлагыг дэлгэрүүлэн, хуучин нийгмийн үзэл санаа дадал заншлын эсрэг зарчимт тэмцэл хийх явдал мөн. Энэ зорилтыг биелүүлэхэд ухуулагч нар их үүрэг гүйцэтгэх ёстой.

Ухуулагч бүр хөдөлмөрчдийн мэдлэг боловсролын хэмжээ, эрхэлж байгаа ажил төрлийн онцлогийг нарийн судалж, ухуулгыг амьдралтай холбож хийвэл үр нөлөөг нь дээшлүүлж чадна.

Эрдэнэсантын Г.Дамдинсүрэн, Мөнгөнморьтын Ц.Базаргүр, Заамарын Б.Дагвадорж, Эрдэнийн Ж.Жамъян, Баян-өнжүүдийн В.Ажваа нарын зэрэг ухуулгын үр дүйг сайн эзэмшиж ухуулгыг үйлдвэрлэл, цаг үеийн зорилттой нягт холбоон бүтээлчээр явуулдаг тэргүүний ухуулагчид олон байна.

Ухуулгын ажлын үр нөлөө нь эцсийн эцэст түүнийг эрхлэн хийдэг ухуулагч, улс төрийн мэдээлэгчдийн онол, ажил төрлийн мэдлэг, ухуулан ойлгуулах үр чадвар, идэвх хариуцлагаас шалтгаалах учир тэдний боловсрол мэдлэгийг дээшлүүлж, идэвх хариуцлагыг өндөржүүлэх талаар намын байгууллага бүр ихээхэн санаачилга тавьж ажиллавал зохино.

Ухуулагч бүр онол улс төр, эдийн засгийн мэдлэгээ байнга дээшлүүлэхийн зэрэгцээ ухуулгын олон талт арга барилыг чадамгай эзэмшиж ухуулгад төрөл бүрийн аппарат хэрэгсэл, үзүүлэн таниулах материалыг өргөн ашиглах нь чухал.

Ухуулгыг цаг үе, тухайн үйлдвэрлэлийн үе шат, хөдөлмөрчдийн байршилд зөр зохицуулах хэрэгтэй. Одоо намын ухуулга хүмүүжлийн ажлыг зун цагийн ирмүүн хөдөлмөр, малчид хөдөлмөрчдийн байршилд өвөрмөцөөр тохируулах, нэгдсэн зуслангийн газруудад ухуулга лекц киноны нээлттэй талбай байгуулах, отрын айлууд, тариа ногооны бригад, саалийн тасгаар авто клуб, сурталчлан туслах бригад аялуулах, ухуулагчдын групп байгуулж ажиллуулах, тэдэнд айл өрхийг хуваарилан өгч цуваа графикаар явуулж ухуулга хийлгэх шаардлагатай байна.

Ардын хувьсгалын 53 жилийн ой, МАХН-ын III их хурал болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтсан ажлыг хөдөлмөрийн хамт олны идэвх чармайлтыг дайчлан V таван жилийн төлөвлөгөөний дөрөв дэх жил-1974 оны зорилтыг биелүүлэхэд ухуулга хүмүүжлийн ажлыг чиглүүлэн зохиоход намын байгууллагууд онцгой анхаарч ажиллавал зохино.

НАМЫН БАГА ХУРАЛ УГТАЖ...

Аймгийн намын XVI бага хурал угтаж тус аймаг дахь тэжээлийн фондын улсын контор V таван жилийн эм хэрэглэл, тэжээл, үр борлуулах төлөвлөгөөг 1 жил 9 сарын өмнө 200,1 хувиар биелүүлээ.

Тус конторын хамт олон социалист уралдаанаар жигүүрлэн байгууллагаараа социалист хөдөлмөрийн төлөө хамт олон болж энэ оны эхний 5 сарын бараа борлуулах төлөвлөгөөг 319,9 хувиар, 1974 оны бүтэн жилийн төлөвлөгөөг 140 хувиар биелүүлж сайхан амжилт гаргалаа.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны заавал биелүүлэх шийдвэр

1974-6-5

Зуун мод хот

Согтууруулах ундааг худалдах, бэлтгэх явдалтай холбогдсон зарим зүйлийг зохицуулах тухай

Согтуурах явдалтай хийх тэмцлийг хүчтэй болгох тухай БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1974 оны 120 дугаар зарлигийг биелүүлэх зорилгоор аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. Зуун мод хотод зочид буудлын төв гуанзантаас бусад гуанз, нийтийн хоолны газарт архи дарс худалдаалахыг хориглосугай.

2. Тус аймгийн нутаг дэвсгэр дээр дэлгүүр, мухлаг, агент, авто худалдаа, буфетүүдэд тогтоогдсон өдөр цагт архи дарс, худалдахыг хориглосугай.

3. Ус, чихэрт тараг холих замаар согтууруулах ундааны зүйл бэлтгэх явдлыг хориглосугай.

4. Согтуурах явдалтай тэмцэх ажлыг байнга сис-

темтэй арга хэмжээ болгон явуулж сурталчлах, зөрчил дутагдал гаргасан этгээдүүдэд хууль тогтоомжийн зохих заалтын ёсоор хариуцлага хүлээлгэн арга хэмжээ авч байхыг сум, хот, хороодын гүйцэтгэх захиргаа, албан газар, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

Энэ шийдвэрийг зөрчсөн хүмүүсийг сум, хот, хороодын АДХ-ын гүйцэтгэх захиргааны дэргэдэх захиргааны комисс сануулах, түүнчлэн 200 хүртэл төгрөгөөр торгож байсугай.

Энэ заавал биелүүлэх шийдвэр нь Төв аймгийн нутаг дэвсгэр дээр 1974 оны 6 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 2 жилийн хугацаагаар хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга Ч. ДАШДЭМБЭРЭЛ
Аймгийн АДХ-ын гүйцэтгэх захиргааны хариуцлагатай нарийн бичгийн дарга Г.ШАРАВ



Батсүмбэрийн САА-н ногоочин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Д.Долгор, хүнсний ногооны нарийн мэргэжилд олон залуусыг дагалдуулан сургажээ.

БНМАУ-ын хөдөлмөрийн баатар, ногоочин Д.Долгор аймгийн намын XVI бага хуралд төлөөлөгчөөр сонгогдоод байна.

ЗУРАГ ДЭЭР: Д.Долгор, БНМАУ-ын аварга ногоочин Х.Хандаа, Ж.Дүүжий нарын хамт байцааны үрслэг бойжуулж байгаа нь

ТАРИАЛАЛТЫН ЯВЦЫН МЭДЭЭ

Аймгийн хэмжээгээр 6 дугаар сарын 8-ны байдлаар 113,5 мянган га-д үрлэлт хийж төлөвлөгөөний 95,0 хувийг биелүүлээд байгаагийн дотроос үр тариа тариалалтын төлөвлөгөөг 102,0 төмсний 88,4 хүнсний ногооны 73,0, тэжээлийн ургамлын 39,4 хувийг тус тус биелүүлээ.

Тариалалтын төлөвлөгөөний биелэлтийг сумдаар үзүүлбэл: (Хувиар)

	Нийт талбай	үүнээс төмс	хүнсний ногоо
Алтанбулаг	36,1	100,0	53,3
Батсүмбэр	85,2	100,0	53,4
Баян	30,8	100,0	100,0
Баян-өнжүүл	29,7	150,0	83,3
Баяндэлгэр	84,7	125,0	76,9
Баянжаргалан	62,2	100,0	0
Баянзүрх	71,3	100,0	72,7
Баянцагаан	19,0	66,6	0
Баянцогт	98,9	105,0	60,0
Борнуур	91,2	110,0	88,8
Бүрэн	33,6	100,0	33,3
Дэлгэрхаан	60,0	100,0	33,3
Жаргалант	99,4	57,1	77,4
Заамар	70,1	56,0	28,5
Лүн	83,2	100,0	75,0
Мөнгөнморьт	25,7	100,0	100,0
Өндөрширээт	91,7	100,0	50,0
Сэргэлэн	44,1	100,0	62,5
Угтаал	101,4	100,0	100,0
Эрдэнэ	62,4	140,0	100,0
Эрдэнэсант	100,1	100,0	66,6
Архуст ТAA	102,3	4 да	60,3

Статистикийн товчоо

СУББОТНИКООР

Зуун мод хотын албан байгууллага, үйлдвэр аж ахуйн газрын ажилчин, албан хаагчид хот орчноо тохижуулах ирмүүн хөдөлмөрт амжилттай ороод байна. Энэ зургадугаар сарын 2,8-ны Бямба гаригт хотын төвийн 22 албан байгууллагын 650 гаруй ажилчин, албан хаагчид, хотын төв цэцэрлэг, замын орчимд хавтан суулгах, хар шороо зөөж зүлэг суулгах зэрэг 3051 куб-метр газар шорооны ажил хийлээ. Энэ ажилд байгууллагынхаа хүн хүчийг сайн зохион байгуулж хуваарьт газар шорооныхоо ажлыг хугацаанд нь дуусгасан байгууллага газар нилээд байгаагийн дотор Шүүх, Прокурор, Эрүүлийг хамгаалах газар, Тээврийг удирдах газар, 13 дугаар авто бааз, Хүнсний комбинат, Ойн аж ахуй, Усны аж ахуйг удирдах газар 96-222 кубметр газар шорооны ажил хийх хуваарь авч үр ажлаа хугацаанд нь чанартай дуусгаж амжилттай ажиллав.

Аймгийн ХЗЭ-ийн илгээлгийн эздийн чуулга уулзалт дээр МХЗЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Ч. ПҮРЭВЖАВ-ын хэлсэн үг*

HEXED 001
TAR 000000

[illegible][illegible]

ЗАЛУУЧУДЫН ДАЙЧИН ХЭВЛЭЛ

[illegible][illegible][illegible][illegible][illegible][illegible]

Таблица 1. Социал-экономические условия жизни населения Республики Узбекистан. Динамика основных показателей за период 1990-1999 гг.

Показатель	1990	1991	1992	1993	1994	1995	1996	1997	1998	1999
Численность населения, млн.	18,5	18,6	18,7	18,8	18,9	19,0	19,1	19,2	19,3	19,4
Уровень жизни, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
ВВП на душу населения, тыс. долл.	1,2	1,3	1,4	1,5	1,6	1,7	1,8	1,9	2,0	2,1
Индекс цен, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс заработной платы, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс пенсий, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на здравоохранение, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на образование, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на культуру, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на спорт, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на туризм, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на транспорт, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на связь, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на жилищно-коммунальное хозяйство, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на здравоохранение и образование, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на культуру, спорт и туризм, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на транспорт, связь и ЖКХ, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109
Индекс расходов на все перечисленные сферы, индекс	100	101	102	103	104	105	106	107	108	109

[illegible]

Нөхөр Ч. ПҮРЭВЖАВ-ын хэлсэн үгийн төгсгөл

(Түрүүч нь II пүүрт)

Төв аймагт ерөнхий боловсролын дунд сургууль төгсөгчдөөс МХЗЭ-ийн илгээлтээр 1300 охид хөвгүүд гарч, үүнээс 1054 нь шууд үйлдвэрлэл дээр ажиллаж байна.

Тус аймгийн ХЗЭ-ийн хорооноос илгээлтийн эздийн тогтвор суурьшил, ажил хөдөлмөр, соёл ахуйн байдалд үзлэг хийж, удирдамж гаргал тэдний ажиллах нөхцөл соёл ахуйн үйлчилгээгээр хангах талаар арга хэмжээ авч, тэргүүний туршлагатай ахмад хүмүүсийн туршлагыг эзэмшүүлэн гэрчилгээ олгох, хичээл заах зэрэг нилээд ажил зохиожээ.

Ийм зохион байгуулалттай арга хэмжээ авснаар илгээлтийн эздийн ажлын туршлага сайжирч хариуцсан ажлынхаа, үйлдвэрлэлийн даалгавар, төлөвлөгөөг биелүүлэх явдалд ахицтай нөлөө үзүүлж байна.

Жаргалант, Батсүмбэр зэрэг сумын ХЗЭ-ийн байгууллага илгээлтийн эздийн чуулга уулзалт хийж, ажлыг нь дүгнэж тэдний дунд тодорхой ажил зохиож байхад Баян, Эрдэнэ, Сэргэлэн суманд илгээлтийн эздийн санаа сэтгэл, зориг эрмэлзлэлийг хөдөлгөөнөөр ажил зохиохгүй, тэднийг халамжлах талаар бага анхаарснаас илгээлтийн эздийн тогтвор суурьшил муу байгаад дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй байна.

Төв аймгийн нэг онцлог бол нийслэл Улаанбаатар хоттой ойр учир зарим САА, нэгдэл нийслэлийн сургуулиудын хөдөлмөр, амралтын зусангийн түшиц газар болдог.

Иймд сурагчдад багаас нь хөдөлмөрийн дадлагыг олгох ХАА-н үйлдвэрлэлтэй танилцахад нь орон нутгийн нам, улс, эвлэ-

лийн байгууллага онцгой анхаарч их үүрэг гүйцэтгэх нь цаашид ч их нэмэгдэх зорилт юм.

Манай өнөөгийн залуу үеийг тал бүрээр дэмжин тусалж мал аж ахуйн үйлдвэрлэлийн шилдэг мастер, хөдөлмөрийн алдар цуутан болгон хүмүүжүүлэх явдал орон нутгийн нам, захиргаа, олон нийт, ХАА-н байгууллагуудын чухал зорилт болж байна.

Охид хөвгүүдийг илгээхэд ЗСБНХУ-ын комсомолын байгууллагын хуримтуулсан баялаг туршлагын сангаас үлгэр дуурин авч ахуй маш их байна.

1974 оны 4 дүгээр сард Москва хотноо хуралдаж өнгөрсөн ВХЛКЗЭ-ийн ээлжит XVII их хурал Зөвлөлтийн ерөнхий боловсролын сургууль, ТМС төгсөгчдөөр ажилчин, тариачдын залуу халааг бэлтгэх асуудал дээр ихээхэн анхаарсан билээ.

Ийм учраас ХЗЭ-ийн байгууллагууд ажилчин малчин залуучуудын залгамж халааг бэлтгэж байгаа ТМС-иудыг шөвлөн авч ажиллах хэрэгтэй байна. Одоо МХЗЭ-ийн илгээлтээр ХАА-н үйлдвэрлэлд гарч ажиллаж байгаа охид хөвгүүдийг нийгмийн өмч хөрөнгө, ялангуяа нийгмийн мал сүргэт өөриймсөг ханддаг болгон хүмүүжүүлэхэд ХЗЭ-ийн байгууллага онцгой анхаарч ажиллах хэрэгтэй.

Залуучуудын хүчийг сайн зохион байгуулж хадлан авах, тариа ногоо хураах, өвлийн бэлтгэл хангах зэрэг цаг үеийн кампант ажлыг хугацаанд нь чанартай сайн гүйцэтгэх нь эвлэлийн байгууллагын нэг чухал үүрэг мөн. Мал сүргийг отроор таргалуулах, авах ашиг шимийн төлөвлөгөөг биелүүлэх, бүтээгдэхүүний

чанарыг эрс дээшлүүлэх ба малын зүй бус хоргодлын шалтгааныг илрүүлж хоргодлыг багасгахад илгээлтийн эзэд хошуучлан оролцож гарсан төлөө гардалгүй бойжуулан 100 эхээс авах төдийн талаар МХЗЭ-ийн Төв Хорооны VI бүгд хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх, төл сэнсрэхээс урьдчилан сэргийлэх арга ажиллагааг эзэмших хэрэгтэй байна.

Орон нутгийн ХЗЭ-ийн байгууллага илгээлтийн эзэн бүрээр уралдааны үүргийг тодорхой судалгаа үндэслэлтэй авахуулах ажлыг зохиож, төлөвлөгөөг хугацааны өмнө биелүүлэх ажлыг 1974 оны бүх ард түмний социалист уралдаанд өндөр амжилт үзүүлэх уриан дор явуулж нийт МХЗЭ-ийн илгээлтийн эздийн хөдөлмөр, улс төрийн идэвхийг бүх талаар өрнүүлэн ажиллах нь чухал.

Илгээлтийн эзэн залуу малчдын эрхэм чухал зорилт бол ажиллах, сурах, мэдэх талаар өөртөө өндөр шаардлага тавин ажиллаж социализмын үеийн шинэ хүний хөдөлмөрч хичээнгүй шилдэг чанарыг эзэмшиж мал маллах арга ажиллагаанаа соёлыг аймагт дээшлүүлэх эрхэлсэн ажлынхаа жинхэнэ эзэн нь болох явдал юм.

Илгээлтийн эзэн залуу малчин бүхэн мал аж ахуйн үйлдвэрлэлийн олон талын арга ажиллагааг улам бүр нарийсгаж, мал маллах ажилд шинжлэх ухаан техникийн ололт тасаралтгүй нэвтэрч байгаа одоо үед ахмад малчдын баялаг туршлагыг зоо-мал эмнэлгийн - шинжлэх ухааны мэдлэгтэй нягт зөв хослуулан малчны мэргэжлийг чадамгай эзэмших ёстой.

МАХН-ын XVI их хурлаас ахмад үеийн нэр төртэй залгамжлах халааг бэлтгэхийг МХЗЭ-ийн гол

зорилт гэж заасан билээ. Намын энэ заалтыг эвлэлийн байгууллага үйл ажиллагаандаа удирдлага болгон хэрэгжүүлэхийн тулд дараах үндсэн зүйлст анхаарч ажиллах нь зүйтэй.

—Хөдөлмөрийн алдар сэдэвт тэргүүн туршлагын болон үзүүлэх сургуулийг бригад суурьт зохиох.

—Залуучуудын эдийн засгийн мэдлэгийг дээшлүүлэхэд онцгой анхаарал тавьж суурин анхан шатны тоо бүртгэлийг тогтмол хөтлүүлж заншуулах.

—Гавшгай бригадыг залуучуудад хөдөлмөрийн хүмүүжил олгох нэг ёсны сургууль болтол чанаржуулж түүнд гишүүд залуучуудыг өргөн оролцуулах.

—Залуу хүн бүр хувийн нэгдсэн төлөвлөгөөтэй ажиллаж сурах.

—Хөдөлмөр-үйлчилгээний соёлч байдлыг дээшлүүлэхэд гишүүд залуучууд хошуучлах.

—ХАА, нэн ялангуяа МАА-н үйлдвэрлэлийг эрчимтэй хөгжүүлэх, малыг тогтвортой өсгөхөд ХЗЭ, түүний гишүүдийн идэвх оролцоо санаачилгыг бүх талаар өрнүүлэхэд анхаарах хэрэгтэй.

ХАА-н үр тарианы болон бүх тарималын ургац дээшлүүлэхийн төлөө тэмцэл бол эвлэл, түүний гишүүд залуучуудын тодорхой үйл ажиллагаа байх ёстой.

Тэргүүний тариаланч, механикжуулагч, малчдын нэр хүндийг өндөр өргөж алдаршуулах ажлыг эрчимтэй зохиох хэрэгтэй.

Байгаль орчноо хамгаалахад залуучууд идэвхтэй оролцож төрж өссөн эх нутгаа хайрлах, түүний ёсоор баялгийг эзний ёсоор хайр гамтай ханддаг болгон хүмүүжүүлэх нь ХЗЭ-ийн байгууллагын эх оронч үүрэг мөн.

Шинжлэх ухаан шууд

үйлдвэрлэх хүч болсон эрин үеийн шинжлэх ухаан техникийн ололт амжилтыг социализмын ололт амжилтын давуу талтай өвтэгш хослуулан ажиллах явдал чухал зорилт болж байна.

Үүний тулд: Залуу хүн бүр шинжлэх ухааны өргөн их мэдлэг эзэмшин шинжлэх ухаан техникийн ололтыг чадамгай эзэмшиж техникийн хүч чадлыг дүүрэн ашиглах, аливаа ажил бүхний чанарт тавих анхаарлыг өндөржүүлэх хэрэгтэй байна.

Материаллаг үйлдвэрлэлд ажиллаж байгаа залуу ажилчин, малчдыг суурьшуулах тэдний ахуй байдалд эвлэлийн байгууллага халамж анхаарал үзүүлэх хэрэгтэй. Тэдний эрэлт сонирхлыг судлах, шинэ мэргэжлийг эзэмшүүлэх, мэргэжлийн дээшлүүлэхэд зүйл бүрээр туслах, хөдөлмөрийн бүтээмжийг өндөржүүлэх, сурч боловсрох, ажиллах, амрах ахуйн зохих нөхцөлийг бүрдүүлж өгөхөд их санаа тавих ёстой. Юуны өмнө ажил хөдөлмөрийн замд эхлэн орж байгаа хөвгүүд, охидод их анхаарал тавивал зохино.

Ажилчин, малчин залуучууд бол МХЗЭ-ийн зүрх сэтгэл, оюун ухаан юм. Иймд эдгээрийг аль болох олноор эвлэлийн эгнээнд олох хэрэгтэй.

Бид ахмад үеийнхэсээ илүү их зүйлийг хийж бүтээх тавилантай төрсөн улсаа. Ийнхээс нэг төрлийн ажлыг уйгагүй дагнаж сайн хийх хэрэгтэй болж байна. Гайгчүү хөдөлмөрийн үйл явцад залуу хүний сайн сайхан чанар бүрэлдэх учиртай гэдгийг бид хэзээ ч мартаж ёсгүй.

МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласны түүхт 50 жилийн ойг угтсан ирмүүн хөдөлмөртөө их амжилт гаргахыг та бүхнээс хүсэн ерөөе.

ҮЭ-ИЙН БАГА ХУРЛЫН ТӨЛӨӨЛӨГЧ

Жаргалантын САА-н тракторчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар М. Чойжамц ажил үйлсээрээ шалгарч аймгийн үйлдвэрчний эвлэлийн XVII бага хуралд төлөөлөгчөөр сонгогдов.

М. Чойжамц анх 1962 онд Жаргалантын САА-н Загдал тасагт тракторчнаар очиж ажилласнаар их амьдралын замаа эхэлж, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар гэдэг эрхэм хүндэт алдар хүлээсэн юм. М. Чойжамц сүүлийн 10 жилд «ДТ-54» трактортаар 17 жил 5 сарын ажил гүйцэтгэсний дээр 5 жилд 9 жил 2 сарын ажил гүйцэтгэхээр социалист уралдаанд үүрэг авч 1974 оны 5 дугаар сарын 30-ны байдлаар 6 жил 4 сарын ажил гүйцэтгээд байна.

М. Чойжамц эзэмшсэн трактороо их засваргүйгээр 11 жил ажиллуулахдаа их засварын нормыг 7584 зөөлөн га-аар давуулж, запас хэмнэлтээс 13878 төгрөг, шатахуун хэмнэлтээс 26174 төгрөг бүгд 40052 төгрөгийн арвиан хэмнэлт гаргажээ.

М. Чойжамц ярихдаа: —Ажилд амжилт гаргах үндэс бол юуны өмнө ажлын нарийн тооцоо, тухайлбал: жил, улирал, сар, өдөр, цагийн төлөвлөгөөтэй ажиллах, эзэмшсэн техникээ хайр гамтай эдлэж үйлчилгээг тогтоосон хугацаанд нь чанар сайтай хийж байх, ажиллах амрах цагийг хатуу журамлан нарийн хуваарь төлөвлөгөөтэй ажиллах явдал гэж үздэг байна.

Тэрээр техник засвар,

техникийн тохируулга үйлчилгээг цаг хугацаанд нь хийж моторын түлшний ямагт цэвэр байлгах талаар үргэлж анхаарч, түлшний савны доторх тунадасыг тогтмол цэвэрлэж, бүдүүн шүүрийг 24 цаг тутам 1 удаа цэвэрлэж 120 цаг ажиллуулдаг угааддаг.

Мөн нарийн шүүрийг 50-60 цаг ажиллуулдаг тунадасыг астаж угаалгийн дээр их бохирдсон байвал гадна талыг хуулж тусгай ноосон даавуугаар ороож тавьдаг. Ингэж түлшийг цэвэр байлгах нь тракторын мотор түлшний аппаратад эвдрэл гэмтэл тохиолдохгүй хүч сайтай, удаан эдлэх нөхцөл болдог юм гэж ярих.

Н. ДУМАА

СААЛЧИН БОЛОХ ОХИН

Аймгийн төвийн 8 жилийн дунд сургуулийн 7 дугаар ангийн сурагч Лхагвасүрэнтэй уулзахад: Хөдөхөн хоногийн дараа 7 дугаар ангиа төгсөөд хөдөө нутагт хөдлийн жолоог залж намынхаа уриа, эвлэлийн илгээлтээр өөрийн өсөж төрсөн нутаг Баян-Өнжүүл сумын «Бүрд» бригад саальчин болохоор саналаа өгөөд байна.

Би сайхан болж өнгөрсөн аймгийн илгээлтийн эздийн чуулга уулзалтад оролцож алдар гавьяатнууд, ахмад үе, анх нөхцөлийнхөн арвин баялаг туршлагаас ихийг сонсож мэдлээ.

Чуулга уулзалтад үг хэлсэн олон хүний яриа миний сэтгэлийг ихэд хөдөлгөж илгээлтээр гарч ажиллахаар шийдэж байсан намайг улам зоргожуулав.

Ялангуяа МХЗЭ-ийн Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга Э. Пүрэвжав гуайн хэлсэн үг надад их зүйлийг бодогдуул-


сан. Илгээлтээр очсон газраа биеийн амрыг харж залхууралгүй, хүчээ байхал үр бүтээлтэй ажиллаж амжилт гаргавал коммунизм байгуулж байгаа. Зөвлөлт орны туршлагатай биечлэн танилцаж болох юм байна гэсэн сэтгэгдэл төрлөө.

Тус чуулгын үеэр байгуулагдсан үзэсгэлэнгээс миний айл 7 дугаар ангиа төгсөөд саальчин болсон илгээлтийн эзэн Батсүмбэрийн САА-н саальчиг Эрдэнэ-цэцэг, Баянчанданкий саальчин Ничирхорлоо нарын амжилт туршлагатай танилцлаа.

Энэ нь бушуухаа, саальчин болж эд нар шиг амжилт гаргах юмсан гэсэн хүслийг минь улам баталгав. Эвлэлийн илгээлт өөрлөх, сэтгэл булаасан хөдөө нутагт очиж ажиллахыг энэ жил 7 дугаар ангиа төгсгөх гэж байгаа үе чатуулан найз та нартаа уриалж гэж ярих.

С. ЖУДАГ

ХӨДӨӨГИЙН ЗАЛУУЧУУД, ЭМЭГТЭЙЧҮҮДИЙН СПАРТАКИАД



Спартакиадын нээлтийн ажиллагаа

Аймгийн хөдөөгийн залуучуудын III, эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиад энэ сарын 8-9-ний өдрүүдэд Зуунмод хотод явагдлаа.

Баярын гоёлоор чимэглэгдсэн төв цэнгэлдэх хүрээлэнд 6 дугаар сарын 8-ны 13 цаг болоход үзэгчид суудлаа эзлэж тамирчдын жагсаал жигдрэн спартакиадад төв, хөдөөгийн 43 зөвлөлөөс шалгарсан 500 гаруй тамирчид спортын уран чадвараа сорив.

Хөдөөгийн залуучуудын III спартакиадын эрэгтэй, эмэгтэйчүүдийн 100, 200, 400, 800 метрийн зайн гүйлтүүдэд Алтанбулаг сумын тамирчин Баатар, мөн сумын тамирчин Батцэнгэл, Хишгээ, Отгонбаяр, Баянчандма-

хэлсний дараа тамирчдын жагсаал явж, үндэсний бөхийн барилдаанаар спартакиадын ажиллагаа эхэллээ.

Аймгийн хөдөөгийн залуучуудын III спартакиадад нийт нэгдэл, САА, ТАА 25 нэгжээс шалгарсан 417 тамирчин, аймгийн эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиадад төв, хөдөөгийн 43 зөвлөлөөс шалгарсан 500 гаруй тамирчид спортын уран чадвараа сорив.

Хөдөөгийн залуучуудын III спартакиадын эрэгтэй, эмэгтэйчүүдийн 100, 200, 400, 800 метрийн зайн гүйлтүүдэд Алтанбулаг сумын тамирчин Баатар, мөн сумын тамирчин Батцэнгэл, Хишгээ, Отгонбаяр, Баянчандма-

ний тамирчин Насан-очир, Жаргалантын САА-н тамирчин Баасанбаяр нар түрүүлэв.

Мөн 4X100 м-ийн зайд эрэгтэй, эмэгтэйчүүдээс Насан-очир ахлагчтай Баянчандманий, Хишгээ ахлагчтай Алтанбулагийн баг тамирчид 1 дүгээр байр эзлэж, Жаргалантын САА-н Ганболд, Баяндэлгэрийн Мянгарчимэд, Сарантуяа, Өндөрширээтийн Балжмаа ахлагчтай багууд дараах байруудад орлоо. Эрэгтэйчүүдийн 1500, 5000 м-ийн гүйлтэд Жаргалантын САА-н Баасанхүү түрүүлж; Баянжаргалангийн Дагвадоо, Баяндэлгэрийн Лантуу нар 2, 3 дугаар байр эзлэв.

Үндэсний бөхийн барилдаанд Эрдэнэсантын ТАА-н тамирчин, цэргийн арслан Амгалан түрүүлж, Батсүмбэрийн САА-н тамирчин, аймгийн начин Сандагдорж үзүүр булаацалдав.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн сур харвалтын тэмцээнд Баянжаргалан сумын тамирчин Өлзийбат, Загд нар түрүүлж, Баяндэлгэрийн Хурцбилэгт, Мөнгөнморьтын Нямаа, Замарын Цэрэндүлам, Алтанбулагийн Нансалмаа нар дараах байруудад шалгарав.

Эрэгтэй, эмэгтэйчүүдийн шатрын тэмцээнд Баянчандманий Дашдондог, Өндөрширээтийн Оюунхорол нар нэгдүгээр байр дараах байруудад Өндөрширээтийн Пүрэвсүрэн, НДҮ-ийн Гунаа, Баянчандманий Оюунгэрэл, Баян-өнжүүлэйн Долгорсүрэн, одон бөмбөгийн тэмцээнд эрэгтэйчүүдээс Сэргэлэнгийн Дэмбэрэлпүрэв, эмэгтэйчүүдээс Заамрын Найнцэцэг нар түрүүлж удаах байруудыг Лунгийн Батсүх, Жаргалантын Лхагва, Баянчандманий Тунгалаг, Эрдэнэсантын ТАА-н Дорж, эрэгтэйчүүдийн бөөрөнцөг, зээрэнцэг шидэлтэнд Жаргалантын Баттөмөр, эмэгтэйчүүдээс Эрдэнэсантын ТАА-н Чулуундуслам, Баянчандманий Цэдэн-иш, урт өндрийн харилтанд эмэгтэйчүүдээс Өндөрширээтийн Найданхүү Жаргалантын Ганболд, эмэгтэйчүүдээс Сэргэлэнгийн Дунжмаа нар түрүүлэв.

Хөдөөгийн залуучуудын III спартакиадын үеэр

эмнэг булгиулах үзүүлэх сургууль болсны гадна энэ онд хамгийн олон эмнэг хангал уналга эдэлгээнд сургаад байгаа залуучуудыг шалгаруулахад Баянжаргалан сумын Навааносор түрүүлж, Эрдэнэсантын ТАА-н Загдбазар, Алтанбулаг сумын Гончигжав нар дараах байруудад орсон байна.

Хөдөөгийн залуучуудын III спартакиадад оролцсон сум-нэгдэл, сум, САА, ТАА-нуудаас Алтанбулаг сумын «Хөдөлмөр» нэгдэл 105 оноогоор 1 дүгээр байр эзлэж, I зэргийн диплом, 1500 төгрөг, Жаргалантын САА 104 оноогоор 2 дугаар байр эзлэн II зэргийн диплом, 1200 төгрөгөөр, Баяндэлгэр сумын «Хэрлэн-баян» нэгдэл 99 оноогоор III байр эзлэж, III зэргийн диплом, 1000 төгрөгөөр тус тус шагнагдлаа.

Хөдөөгийн залуучуудын III спартакиадаас Дундговь аймагт болох бүсийн тэмцээнд 20-иод тамирчин оролцохоор шалгарлаа.

Аймгийн эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиадын 100, 200, 400, 800, 1500-метрийн зайн гүйлтэнд Алтанбулагийн Батцэнгэл, Зуунмод хотын тамирчин Энхтуяа, Пүрэвжав, Алтантуяа, Баянчандманий Чулуунцэцэг нар түрүүлж, 4X100 метрийн гүйлтэнд Зуунмод хотын Даваа ахлагчтай баг 1 дүгээр байр эзлэж, Алтанбулагийн Хишгээ, Баяндэлгэрийн Сарантуяа ахлагчтай баг удаах байранд орлоо.

Урт өндрийн харилтанд Сэргэлэн сумын

Дунжмаа түрүүлж, Зуунмод хотын тамирчин Энхтуяа, Эрдэнэцэцэг, Алтанбулагийн Батцэнгэл, Баяндэлгэрийн Цэрэнханд, зээрэнцэг шидэлт, бөөрөнцөг түлхэлтийн тэмцээнд Зуунмод хотын тамирчин Балжинням, Эрдэнэсантын ТАА-н тамирчин Чулуундулам нар, таван төрөлтийн тэмцээнд Зуунмод хотын тамирчин Даваа түрүүлж, Алтанбулагийн Уртнасан, Баян-өнжүүлэйн Энхжаргал нар 2, 3 дугаар байр эзлэв.

Шатрын тэмцээнд Зуунмод хотын тамирчин Хишигдолгор, одон бөмбөгийн тэмцээнд Зуунмод хотын тамирчин Чулуунцэцэг нар тус тус түрүүлэв. Гар бөмбөгийн тэмцээнд Зуунмод хотын тамирчин Дондовоо ахлагчтай баг 1 дүгээр байр, Баянчандманий Дуламсүрэн ахлагчтай баг 2 дугаар байр, Батсүмбэрийн Долгорсүрэн ахлагчтай баг 3 дугаар байр эзлэв.

Аймгийн эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиадад Зуунмод хотын эмэгтэйчүүдийн зөвлөл 323 оноогоор 1 дүгээр байр эзлэж аймгийн эмэгтэйчүүдийн зөвлөлийн баярын бичиг 500 төгрөг, Баяндэлгэр сумын эмэгтэйчүүдийн зөвлөл 2 дугаар байр эзлэж мөн баярын бичиг, 300 төгрөг, Алтанбулаг сумын эмэгтэйчүүдийн зөвлөл 3 дугаар байр эзлэж баярын бичиг 200 төгрөгөөр шагнагдлаа.

Аймгийн эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиадаас шидлэг 17 тамирчин Улаанбаатар хотод болох Монголын эмэгтэйчүүдийн анхдугаар спартакиадад оролцохоор шалгарлаа. III ЦЭРЭНДОО

ӨДӨРЛӨГ БОЛОВ

Баянчандманий хорооны нам, олон нийтийн байгууллагаас эрхлэн ахмад настан, гавьяатнуудын өдөрлөг зохиов.

Өдөрлөгт БНМАУ-ын гавьяат багш Сүрэн, хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, МХЗЭ-ийн ууган гишүүн Цэвэгжав, ахмад ажилчин, намын гишүүн Цэдэв, Ханд нарын 50 гаруй хүн оролцож өсвөрийн үеийнхэн, залуучуудад өөрсдийн туулж ирсэн түүхэн замнал, хөдөл-

мөрч баатарлаг жишээнээс ярих. Өдөрлөгт БНМАУ-ын гавьяат багш Сүрэн, намын ахмад гишүүн Цэдэв, Ханд нарын түүх намтар, холбогдох баримт бичиг, гавьяа шагналын зүйлсээр үзэсгэлэн гаргасныг өдөрлөгт оролцогчид сонирхон үзцэгээв. Ахмад настангууддаа зориулж пионер сурагчид ая дууныхаа дээжийг өргөн барив.

Б. ПҮРВЭЭ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ

ЗАРЛАЛ

Тус аймгийн тээврийн байгууллагын зохион байгуулалтанд өөрчлөлт орох болсонтой холбогдуулан бараа материалын тооллогыг 1974 оны 6 дугаар сарын 20-ноос 7 дугаар сарын 5 хүртлэх хугацаанд хийх тул дурдсан хугацаанд авто сэлбэгээр үйлчлэхгүй.

Тээврийг удирдах газар, 13 дугаар авто бааз, зам ашиглалтын ангитай тооцоо бүхий байгууллага эхний хагас жилийн тооцоог нийлж үлдэгдлийг 6 дугаар сарын 25-ны дотор батлахгүй бол цаашид үйлчлэхгүйг мэдэгдье.


Аймгийн Тээврийг удирдах газрын захиргаа



Хөдөөгийн залуучуудын III спартакиадын эмэгтэйчүүдийн уртын харилтанд эхний 3 байр эзэлсэн тамирчид.

ЗУРАГ ДЭЭР (баруун гараас) Алтанбулаг сумын тамирчин Ч. Батцэнгэл, Сэргэлэн сумын тамирчин Дунжмаа, Баянцогтын сангийн аж ахуйн тамирчин Дуламсүрэн.

Ш.ЦЭРЭНДОО-гийн авсан гэрэл зураг



Хөдөөгийн залуучуудын III спартакиадын 4X100 метрийн зайн гүйлтэнд түрүүлсэн Баянчандманий сумын Насаночир ахлагчтай баг тамирчид.

Зураг дээр. (Зүүн гараас) Тамирчин Түвшинцэнгэл, Жаргалаар, Равдандорж Насаночир нар. Л.ГУНГААБУУ-гийн авсан гэрэл зураг.